



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2013 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/92

Улаанбаатар хот

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн  
албан татвар, Агаарын бохирдлын төлбөр хураах  
ажлыг зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.1, 39.2 дахь хэсэг, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт, Нийслэлийн засаг даргын 2013 оны 01 сарын 23-ны өдрийн А/48 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. "Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хууль", "Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор Баянгол дүүрэгт бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлыг төлбөр хураах ажлыг 2013 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 31-ний хооронд, албан татвар, хураамжийг хуулийн хугацаанд төлөөгүй тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дутуу төлөлтийг хураан барагдуулах, хариуцлага тооцох хяналтын үзлэг шалгалтыг 2013 оны 06 дугаар сарын 10-аас эхлэн 06 дугаар сарын 24-нийг дуустал тус тус зохион байгуулсугай.

2. Баянгол дүүрэгт автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр хураах ажлыг зохион байгуулах салбар комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, уг ажлыг зохион байгуулах ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Баянгол дүүргийн хэмжээнд автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр хураах ажлыг зохион байгуулж холбогдох төсөвт хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн ажиллахыг дүүргийн Татварын хэлтэс /Б.Оюунтуяа/, Замын цагдаагийн тасаг /Б.Батболд/, хороодын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр хураах ажлын хүрээнд албан татвар, төлбөр төлсөнийг гэрчлэх наалт тэмдэг олгох ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг дүүргийн Татварын хэлтэс, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр хураах ажилд туслалцаа үзүүлэн хамтын үзлэг

шалгалтыг зохион байгуулахыг дүүргийн Замын цагдаагийн тасаг /Б.Батболд/, хороодын Засаг дарга нарт даалгасугай.

5. Баянгол дүүргийн засаг захиргааны байгууллагууд, нийтийн тээврийн үйлчилгээний болон бусад томоохон аж ахуйн нэгжүүдийн автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөрийг 2013 оны 04 дүгээр сарын 01-ний дотор нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулахыг дүүргийн салбар комисс /Г.Энхболд/, Татварын хэлтэс /Б.Оюунтуяа/-д даалгасугай.

6. Баянгол дүүрэгт автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр хураах ажилд дэмждэг үзүүлэх, мэдээлэл сурталчилгааг иргэд, аж ахуйн нэгжид хүргэх ажлыг зохион байгуулж ажиллахыг хороодын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

7. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр хураах ажлыг удирдамжид заасан хугацаанд зохион байгуулж үр дүнг тооцон ажиллахыг дүүргийн салбар комисс /Г.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ОРОСОО

Баянгол дүүргийн Засаг даргын 2013  
оны 02 дугаар 10-ны өдрийн 182  
1 дүгээр захирамжийн хавсралт

АВТО ТЭЭВЭР БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЛИЙН  
АЛБАН ТАТВАР, АГААРЫН БОХИРДЛЫН ТӨЛБӨР  
ХУРААХ САЛБАР КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Салбар комиссын дарга

Г.ЭНХБОЛД

Гишүүд:

Засаг даргын орлогч

М.БАДРАХ

Тамгын газрын дарга

Э.ДОЛГОРСҮРЭН

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Л.БАТБАЯР

Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн дарга

Б.БАТБОЛД

Дүүргийн замын цагдаагийн тасгийн дарга

Б.ОЮУНТУЯА

Татварын хэлтсийн дарга

И.МӨНХЦЭЦЭГ

Татварын хэлтсийн хураалтын тасгийн  
дарга

С.ЭНХЗУЛ

Татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга

Хороодын засаг дарга нар


Нарийн бичгийн дарга

Д.АРИУНЖАРГАЛ

Татварын хэлтсийн авто тээвэр хариуцсан

татварын байцаагч

Баянгол дүүргийн Засаг даргын 2013  
оны 12 дугаар 20-ны өдрийн 1199  
2 дугаар захирамжийн хавсралт



2013.02.20

Улаанбаатар хот

Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар,  
Агаарын бохирдлын төлбөр хураах ажлыг баянгол дүүргийн нутаг дэвсгэрт  
зохион байгуулах ажлын удирдамж

### НЭГ.АЖЛЫН ЗОРИЛГО

БГД-ийн Татварын хэлтэстэй харилцагч болон тус нутаг дэвсгэрт байрлах аж ахуйн нэгж байгууллага, нийт иргэдийн дунд авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль, агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, 2013 оны албан татвар, төлбөр хураах ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулж татвар, төлбөрийн орлогыг зохих төсөвт төвлөрүүлэх, дээрх ажилд дүүргийн харъяа хэлтэс албад болон хороодын зүгээс оролцох хэлбэрийг тодорхой болгоход энэхүү удирдамжийн зорилго оршино.

### ХОЁР. АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

1. Автотээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр хураах ажлыг засаг даргын захирамжаар байгуулагдсан салбар комисс удирдан явуулна.
2. Татвар болон төлбөрийг хураан барагдуулах, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ажлыг дүүргийн татварын хэлтэс хуулинд заасан хугацаанд, өгөгдсөн төлөвлөгөө ба хуваарийн дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Татвар, төлбөр хураах ажлыг 2013 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2013 оны 06 дугаар сарын 24-ний өдрийг дуустал үндсэн ба хяналтын 2 үе шаттайгаар явуулна.

### ГУРАВ. БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ

1. Дүүргийн салбар комисс нь татвар болон төлбөр хураах ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулах, тулгарч буй асуудлыг шийдвэрлэх, шуурхай удирдлагаар хангах үүрэгтэй.
2. Татвар болон төлбөр хураах, гэрчилгээ, гурвалжин тэмдэг олгох ажлыг хугацааны туршид дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч нар татварын хэлтэс, Хөсөг трейд ХХК болон зарим хороодын байранд байрлах суурин болон явуулын хэсгүүдээр хийж гүйцэтгэнэ.
3. Замын цагдаагийн тасаг нь 2013 оны 06 дугаар сарын 01-нийг хүртэл тээврийн хэрэгсэл эзэмшигч, жолооч нарт зөвлөгөө өгөх, сануулах,

шаардах хэлбэрээр ажиллах ба 2013 оны 06 дугаар сарын 10-аас 24-ний хооронд хяналтын үзлэг шалгалтын шатанд албан татвар, төлбөрөө хуулийн хугацаанд төлөөгүй тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэн, аж ахуйн нэгжид хариуцлага тооцох, бичиг баримтыг хураан хяналтын үзлэг тооллогын нэгдсэн цэгт хүргүүлэх ажлыг зохион байгуулж ажиллана.

4. Хороодын засаг дарга, удирдлагууд хариуцсан хороодын оршин суугч иргэд болон тэнд байрлах аж ахуйн нэгжүүдэд хууль тогтоомж таниулах, зар сурталчилгаа, албан шаардлага хүргүүлэх, татвар болон төлбөрийг хуулийн хугацаанд төлж барагдуулахыг шаардах хэлбэрээр татварын хэлтсийн ажилтнуудтай хамтран ажиллана.
5. Зар сурталчилгааны материал, зарлалыг оршин суугчдад хүргэх ажлыг шуурхай, оновчтой хэлбэрээр зохион байгуулах ажлыг хороодын Засаг дарга болон зохион байгуулагч ажилтан нар хариуцна.